БАТЛАВ: ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.ОТГОНБАЯР

# АЖЛЫН ДААЛГАВАР

**Захиалагч нэгж: <u>Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс</u>**

**Төслийн нэр: <u>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</u>**

**<u>Нэг. Нийтлэг үндэслэл</u>**

- **Бодлогын зорилго:** Энэхүү баримт бичиг нь "Тавантолгой" ХК-ийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсын хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн яамны бодлого аргачлал, журам, зааврын дагуу нэгдсэн бодлого, зарчмаар зохицуулахад оршино.
- **Зориулалт**: "Тавантолгой" ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэхэд баримтлах нягтлан бодох бүртгэлийн зарчим, горимыг тодорхойлох ба нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэх зориулалтаар ашиглагдана.

Санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, бусад хэлтэс нэгжээс тайлан, мэдээг тогтоосон хугацаанд батлагдсан загварын дагуу Нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх, хэлтэс, нэгж, ажиллагсдын хоорондын ажлын уялдааг сайжруулах, бүртгэл өөрчлөх боломжгүй удаан хугацаанд тогтвортой мөрдөж ажилладаг нөхцөл бололцоог хангах, ажлын бүтээмж үр дүнтэй байхаар, санхүүгийн дотоод үйл ажиллагаанд өдөр тутам ашиглагдана.

- **Хамрах хүрээ:** "Тавантолгой" ХК-ийн бүх газар, хэлтэс, нэгж, албад
- **Хууль эрх зүйн үндэс**
- Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Татварын багц хуулиуд
- Ашигт малтмалын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Үнэт цаасны тухай хууль
- Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан дүрэм журам
- Монголын хөрөнгийн биржээс гаргасан дүрэм журам
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

**<u>Хоёр. Нягтлан бодох бүртгэлийн зарчим</u>**

- Нягтлан бодох бүртгэлийн суурь зарчмууд /ачааллын зарчим, хос давхар бичилтийн зарчим/
- Хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн систем /энд бусад газар хэлтэстэй хэрхэн уялдах тухай/
- Санхүүгийн тайлан гаргах үндэслэл /хугацаа, форматууд/

***Гүйцэтгэх ажилд тавигдах үндсэн шаардлага:***

1. "Тавантолгой" ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын /салбарын / онцлогт нийцүүлэн СТОУС, НББОУС болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон татвар, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, үйл ажиллагааны хүрээнд мөрдөгдөх хуулиуд, байгууллагын дотоод журам бусад холбогдох дүрэм Засгийн газрын тогтоол. Сангийн яамны журмуудад үндэслэн баримт бичиг боловсруулахдаа Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулинд заасан нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааны дараалын хүрээнд гүйцэтгэнэ.
   - анхан шатны баримт бүрдүүлэх;
   - журналд бичих;
   - дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;
   - ажил, гүйлгээний мэдээ гаргах;
   - санхүүгийн тайлан гаргах гэж заасны дагуу бүхий л үе шатанд анхан шатны баримт бүрдүүлэлт, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх, бүртгэлд тусгах, санхүүгийн програм хангамжтай уялдуулах, бүртгэлээр дамжуулан дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, санхүүгийн үр дүн, санхүүгийн тайлагналын мэдээллийг удирдлагын шийдвэр гаргалтанд ашиглах боломжоор хангасан байхууц байдлаар мэргэжлийн түвшинд ажиллана.
2. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад бүрэн нийцүүлэн сайжруулж, шинэчлэн боловсруулахдаа холбогдох хууль болон тухайн салбарт мөрдөгдөж буй бусад хууль тогтоомж, тухайн салбарын онцлогийг аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлогод тусгасан байна.
3. Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хуулийн дагуу төлж, тайлагнавал зохих орлогын, хөрөнгийн, хэрэглээний албан татварууд, нийгмийн даатгал, төлбөр хураамжуудын тооцоолол, ногдуулалт, тайлагнал, бүртгэлийн үйл ажиллагааг татварын төрөл бүрээр тодорхойлно.
4. "Тавантолгой" ХК-ийн бүх хэрэглэгчдийн авлага, өглөг барагдуулах, тооцооны үлдэгдэл баталгаажуулах,
5. "Тавантолгой" ХК нь нүүрсний ил уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг тул өртөг, бараа материалын үндсэн хөрөнгийн бүртгэлийн тусгай бодлого боловсруулан хэрэгжүүлэх.
6. "Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны чиглэл бүрд нийцсэн санхүүгийн тайлан болон татварын тайланг бэлтгэх талаар дэлгэрэнгүй тусгасан байна.
7. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дотоод журмыг бодлогын баримт бичигтэй уялдуулан дэлгэрэнгүй боловсруулж, шууд дагаж мөрдөхөөр боловсруулах. Мөн холбогдох загвар маягтыг боловсруулсан байна.
8. НББББББ-т компанийн үйл ажиллагаатай холбогдох нягтлан бодох бүртгэлийн жишээг оруулж, тайлбарлах, хэрэглэх, ашиглахад ойлгомжтой ашиглагдахуйц байна.
9. Гүйцэтгэгч нь "Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаа тус бүрээр санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэх, шинээр бодлогын баримт бичиг боловсруулахдаа холбогдох хүмүүстэй зөвшилцөж, стандарттай уялдуулан боловсруулах.
10. Багууд боловсруулсан бодлогын төслийг нэгтгэж, захиалагч, гүйцэтгэгч талын хамтарсан хэлэлцүүлэг хийх, Хэлэлцүүлгийн дараа төслийг бэлэн болгож захиалагч талд өгч, уншуулж, санал тайлбар авах.

11. Ажил үүргийг гүйцэтгэх явцад асуудлын дэлгэрэнгүйг Захиалагчтай харилцан уялдаа холбоотой ажиллах бөгөөд энэ нь ажил гүйцэтгэх явцад боловсруулах баримт бичгийн талаар зөвлөгөө авах, зөвшилцөх, захидал бичгээр харилцах явдал юм.
12. Гүйцэтгэгч нь НББББББ-ийг шинэчлэн боловсруулах ажлыг нарийн цаг хугацаагаар төлөвлөж, асуудлыг оновчтой шийдвэрлэн, зөвлөгөө өгч, гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэж хүлээлгэн өгнө.
13. Шинэчилсэн НББББББ нь аливаа хөндлөнгийн аудит болон хяналт шалгалтын шаардлагыг хангахуйц мэргэжлийн түвшинд боловсруулагдсан байна.
14. Гүйцэтгэгч нь шинэчлэн боловсруулсан НББББББ-ийг хэрэгжүүлэх явцад аудит болон хяналт шалгалтын байгууллагаас алдаа зөрчилтэй гэж үзсэн тохиолдолд уг асуудлаар тухай бүр тайлбар, зөвлөмжөөр хангах, тухайн хэсгийг засах үүргийг хүлээнэ
15. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон шинэчлэн боловсруулсан баримт бичгийн хүрээнд НББББББ нэвтрүүлэхэд арга зүйгээр хангах, санхүү нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад сургалт зохион байгуулах, 40 хүртэл цагийн сургалт, заавар зөвлөгөөг өгнө.
16. Энэхүү ажлын даалгаварт тусгагдсан бүх төрлийн ажил үйлчилгээний дагуу гэрээг биелүүлэхтэй холбоотойгоор гүйцэтгэгчээс гарах бүх зардал, НӨАТ-ын татвар гэрээний үнэд багтсан байна.

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР
2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр